

УЛС ТӨР,  
ОЛОН УЛСЫН  
ХАРИЛЦАА

**БНМАУ-ЫН ТУСГААР ТОГТНОЛ,  
ОЛОН УЛСЫН БАЙР  
СУУРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР ЗХУ-  
ААС ГАРГАСАН ХҮЧИН ЧАРМАЙЛТ**

Р. ОТГОН,  
түүхийн ухааны дэд эрдэмтэн

Олон улсын империализмын колонийн дарлалын эсрэг тэмцэлд дорно дахины ард түмнийг нойрноос сэрээж босгосон аугаа их Октябрийн социалист хувьсгалын шууд нөлөөний дор МАХН-ын удирдлагаар империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгал Монгол оронд 1921 онд ялсан билээ. Монголын ард түмэн социализмын анхны орон Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улсын тусламжтайгаар хатуу ширүүн тэмцлийн үр дүнд эрх чөлөөгөө байлдан олж, Манжийн булаан эзлэгчдийн түрэмгийлэлийн уршгаар XVII зууны сүүлчээр алдсан тусгаар тогтнолоо сэргээсэн юм.

Ардын засгийн газраас Монгол улс тусгаар тогтносон тухай зарлаж дэлхийн олон улстай найрсаг харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа илэрхийлж 1921 оны есдүгээр сарын 14-нд гадаад олон улсуудад хандаж гаргасан тунхаглал бичигт: «Одоо манай ардын засгийн газраас ер Дундад улстай өшөө хорсголыг агуулан байлдан дайтах хэргийг явуулах саналгүй боловч, Хятадын сюзеренитетийг дахин хүлээж хэрхэвч чадахгүй, гагцхүү одоогийн байгуулсан ардын эрхтэй хэмжээт засгийг өөрөө эзэрхэн явуулж, Дундад, Монгол эртнээс харилцан найрамдаж худалдаа арилжааг нэвтрүүлэн Дундад, Монголын хүн иргэнийг тус тусдаа энх түвшний улиралд хандуулахыг гүнээ эрмэлзэн бүхийн дээр бас ч олон улстай гэрээ байгуулан худалдаа арилжааг нэгэн адилаар нэвтрүүлэхийг эрмэлзэн байна»<sup>1</sup> гэж мэдэгдэж Хятад улстай найрсаг харилцаатай байж, мөн дэлхийн бусад улсуудтай найрсаг харилцаа тогтоон хөгжүүлж улмаар худалдаа арилжааг тэгш эрхийн үндсэн дээр хийх хүсэлтэй байгаагаа нотолсон байна. Мөн АНУ-тай найрсаг харилцаа тогтоох эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэн Монгол ардын засгийн газраас Америкийн Нэгдсэн Улсын Гадаад Яаманд 1921 оны есдүгээр сарын 12-нд нот илгээж, уг нотод: «Одоо гагцхүү тусгайлан илтгэх нь манай Засгийн газар хийгээд олны санал бол эрхэм улсын засгийн газраас манай Монголын ардын засгийн газартай эртхэнээ гэрээ байгуулан, элчин сайд суулгаж, худалдаа арилжааг улмаар бадруулан, хоёр этгээдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хүсэж байгаа тул эрхэм сайд та толилж даруйхнаа баяртай хариу хүртээх ажаамуу»<sup>2</sup> гэж мэдэгджээ. Гэтэл хөрөнгөтөн гүрнүүдийн засгийн газрууд манай улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй, Монгол орныг Хятадын хэсэг гэж үзэн, Хятадын засгийн газрын зүгээс Монголд хууль бусаар өнгөлзөж байсныг илэрхий дэмжиж байлаа<sup>3</sup>. Тухайлбал Хятадтай харилцах асуудлаар 1922 оны хоёрдугаар сарын 6-нд Вашингтонд АНУ, Япон, Хятад, Англи, Франц, Итали,

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. боть, 1, УБ. 1964., 7-р тал
2. Мөн тэнд, 6-р тал
3. «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүл, 1985 оны № 2. 13-р тал

Бельги, Нидерланд, Португали улсын төлөөлөгчид гарын үсэг зурсан «есөн гүрний гэрээ»<sup>4</sup> гэгчид Монгол улсыг хүлээн зөвшөөрөхгүй байх гэсэн империалист гүрнүүдийн бодлого тусгалаа олсон байв.

Гагцхүү Зөвлөлт Холбоот Улс л Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудлаар тууштай марксист-ленинист зарчимч байр суурь баримталж байв. Зөвлөлт засгийн газар Хаант Оросоос Монголын талаар байгуулсан тэгш биш бүх гэрээ хэлэлцээрийг цуцалж, Монголын ард түмний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн юм.

Зөвлөлт төрийн тэргүүн В. И. Ленин, Монголын хувьсгалын удирдагч Д. Сүхбаатар нарын идэвхтэй оролцоотойгоор 1921 оны арваннэгдүгээр сарын 5-нд байгуулагдсан Монгол улс, ЗСБНХАУ-ын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай Монгол, Зөвлөлтийн анхны хэлэлцээрээр ардын эрхт Монгол улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлыг социализмын ууган орон, дэлхийн том гүрний нэг ЗХУ албан ёсоор хүлээн зөвшөөрсөн нь Монгол улсын хувьд гадаад, дотоод байдлаа бэхжүүлэхэд улс төрийн чухал ач холбогдолтой байв. Хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа Д. Сүхбаатар зэрэг манай улсын төлөөлөгчдийг В. И. Ленин хүлээн авч уулзахдаа «Танай орны хөдөлмөрчин бүрийн ганц зөв зам бол Зөвлөлт Орос Улсын ажилчин, тариачидтай холбоо тогтоож улс төр, аж ахуйнхаа тусгаар тогтнолын төлөө тэмцэх явдал мөн»<sup>5</sup> гэж заажээ. В. И. Лениний энэ сургаал МАХН, Монголын засгийн газрын гадаад бодлогын үндэс нь болсон юм.

Зөвлөлт Орос улс тэр үед Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон дэлхийн цорын ганц улс байв. ЗХУ ийнхүү Монгол улсыг хүлээн зөвшөөрч, улс төр, эдийн засгийн болон цэргийн тусламж дэмжлэг үзүүлсэн нь БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын чухал хүчин зүйл болсон юм.

БНМАУ-ын гадаад байдал нэн түгшүүртэй болж Японы түрэмгийлэгчид халдан довтолох аюул тулгарч байсан 1930-аад оны дунд үеэр БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх хэрэгт ах дүүгийн ёсоор туслах явдлыг ЗХУ интернационалч үүргээ гэж үзэж «Хэрэв Япон БНМАУ-ын тусгаар тогтнолд халдан довтолохоор шийдвэрлэвэл бид Монгол Ард Улсад туслах болно. Бид Монгол улсад 1921 онд тусалсан шиг тусална»<sup>6</sup> гэж дэлхий дахинд мэдэгдсэн нь Японы түрэмгийлэгчдэд хатуу сануулга болж байв. 1930-аад онд манай оронд гадаадын зэвсэгт халдлагын аюул тулгарч байсантай холбогдуулан 1934 оны арваннэгдүгээр сарын 27-нд БНМАУ, ЗХУ-ын хооронд аль нэг нь гуравдагч улсын зүгээс довтолгоонд өртвөл бие биедээ харилцан дэмжлэг үзүүлэх тухай аман хэлэлцээр байгуулж, уг хэлэлцээрийг 1936 оны гуравдугаар сарын 12-нд харилцан туслах тухай 10 жилийн хугацаатай протокол болгосон билээ. Ингэснээр БНМАУ-ын талаархи Японы милитаристууд, тэрчилэн Монголын тусгаар тогтнолыг устгахыг санаархаж байсан хятадын цэргийн эрхтнүүд, гоминданы эрх баригч бүлгийнхний түрэмгий төлөвлөгөөг биелэх боломжгүй болгосон юм.<sup>7</sup>

Японы милитаристууд 1939 онд БНМАУ-д халдан довтолоход холбоотны үүрэгтээ үнэнч ЗХУ монголын ард түмэнд тусламж үзүүлж, Монгол, Зөвлөлтийн цэрэг энэ түрэмгий халдлагыг няцаан Монголын ард

4. Вашингтонская конференция по ограничению вооружений и тихоокеанскому и дальневосточному вопросам 1921—1922 годов. М. 1924.. с. 78

5. В. И. Ленин. Том. 44, с. 232

6. «Үнэн» сонин, 1986 оны нэгдүгээр сарын 4.

7. «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүл 1985. № 2. 15-р тал

түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг авран гандан бууршгүй гавьяа байгуулсан билээ. Энэ ялалтын дараа 1940 оны долдугаар сарын 9-нд Москвад гарын үсэг зурсан Зөвлөлт, Японы хэлэлцээрээр БНМАУ-ын хилийг Японы түрэмгийлэлийн өмнөх байдлаар Халх голын районд сэргээн тогтоосон нь ЗХУКН, Зөвлөлт засгийн газар Монголын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө их анхаарал тавьдгийн үнэнхүү илэрхийлэл болсон билээ. Энэхүү хэлэлцээр нь БНМАУ-ын хувьд олон улсын эрх зүйн чухал ач холбогдолтой байв. 1948 онд Токиод болсон Японы цэргийн гол гэмт хэрэгтнүүдийг шүүн таслах олон улсын шүүх хуралдаан дээр яллагдагчид БНМАУ-д Японы милитаристууд халдсаныг зөвтгөх оролдлого хийж, тэр үед БНМАУ нь Хятадын хэсэг байсан, биеэ даасан улс биш байсан мэтээр хуурамч шалтаг зааж байсныг америк, Японы шүүгчид ашиглан, эхлээд энэ шүүх хуралдаан дээр «Гадаад Монголын эрх зүйн асуудлыг авч хэлэлцэх шаардлагагүй» гэж үзсэн боловч сүүл сүүлдээ арга буюу энэ асуудалд хариу өгөх болсон юм. Тэгээд тус олон улсын шүүх худалдаанаас 1940 оны долдугаар сарын 9-нд Москвад байгуулагдсан хэлэлцээрийг үндэслэн протоколдоо «... Гадаад Монголын бүрэн эрхт байдлыг тодорхой хүлээн зөвшөөрч, үүний эсрэг нотолгоо байхгүй тул гэмт хэргийн энэ зүйл батлагдаагүй мэт яллагдагчид мэдэгдсэнийг зөвшөөрч болохгүй юм. Мөн түүнчлэн Гадаад Монгол 1945 он хүртэл Бүгд Найрамдах Хятад улсын салшгүй хэсэг байсан мэтээр бүх нийтэд илэрхий зүйл болгож шүүх хуралдаан хүлээн зөвшөөрөх ёстой гэж яллагдагчид мэдэгдсэнийг зөвшөөрч хэрхэвч болохгүй»<sup>8</sup> гэж тэмдэглэжээ. 1941 оны дөрөвдүгээр сард ЗХУ, Японы хооронд төвийг сахих тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан нь Алс Дорнодод энх тайвныг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой үйл явдал болсон билээ. Энэ үеэр ЗСБНХУ, Японы засгийн газрын төлөөлөгчид, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг хүндэтгэх үүргийг Япон улс авсан тунхаглалд гарын үсэг зурсан юм.<sup>9</sup> Эдгээр баримт бичгийг Алс дорнодод энх тайвныг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр боллоо гэж үзэж БНМАУ-ын хөдөлмөрчид талархан хүлээж авсан билээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчид, Ардын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1941 оны дөрөвдүгээр сарын 18-ны хамтарсан хурлын тогтоолд: «1941 оны дөрөвдүгээр сарын 13-ны өдөр гарын үсэг зурж байгуулсан пакт гэрээ ба тунхаглал нь Зөвлөлт Холбоот Улс бол эзэрхэг түрэмгий 2-р дайны дүрэлзэн шатаж буй эдүгээгийн олон улсын хоорондын хүнд байдлын үед эв найрамдлын бодлогыг хэрэг дээр биелүүлэгч ганц улс мөн болохыг дэлхий дахинд хосгүй хүчтэйгээр үзүүлжээ.

... Бүгд Найрамдах Монгол Ард Улсын дэвсгэр нутгийн бүрэн бүтэн ба тусгаар тогтносон байдлыг хүндэтгэж үзэх тухай гарын үсэг зурж баталсан тунхаглал бичиг нь БНМАУ-ыг дайн байлдааны аюулаас холдуулж ЗХУ, БНМАУ-ын ард түмний салшгүй эв найрамдлыг улам цаашид батаар бэхжүүлэх аугаа их шинэ хэрэг болно»<sup>10</sup> гэж онцлон тэмдэглэжээ. 1945 оны хоёрдугаар сард Ялтад болсон ЗСБНХУ, АНУ, Английн засгийн газрын тэргүүн нарын бага хурал дээр БНМАУ-ыг тусгаар тогтносон улс гэж хүлээн зөвшөөрөхийг ЗХУ шаардаж, Японы

8. М. Ю. Рагинский и С. Я. Розенблит. Международный процесс главных японских военных преступников. М-Л, 1950, сс. 199—200

9. Внешняя политика СССР. Т. IV., М. 1946, сс. 550—551

10. МАХН-ын тогтоол шийдвэр, баримт бичгүүд, боть. 3. УБ. 1985. 45-р тал

эсрэг дайнд орох болзлуудын нэг болгож тавьсан билээ. Ялтын бага хурал дээр БНМАУ-ын эрх ашгийг ЗХУ тууштай хамгаалсан юм. БНМАУ дэлхийн II дайны бүр эхнээс Зөвлөлт Холбоот Улс, холбоотон гүрнүүдийн талд бат зогссоныг өрнөдийн гүрнүүд ч харгалзан үзэхгүй байж чадахгүй байв. Ингээд ЗХУ-ын шаардлагыг АНУ, Англи арга буюу хүлээн авч, энэ бага хурлын 1945 оны хоёрдугаар сарын 11-ний шийдвэрт Бүгд Найрамдах Монгол Ард Улсын статус-квог хадгална<sup>11</sup> гэж заажээ. Өөрөөр хэлбэл АНУ, Англи нь БНМАУ-ыг тусгаар тогтносон бүрэн эрхт улс гэж хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.

ЗХУ-ын засгийн газрын тэргүүн И. В. Сталины саналаар АНУ-ын ерөнхийлөгч Ф. Л. Рузвельт БНМАУ-ыг Хятадаар хүлээн зөвшөөрүүлэх талаар ятгах үүргийг Ялтын бага хурал дээр авчээ.<sup>12</sup> Ингээд Ялтад байгуулсан хэлэлцээрийн талаар Хятадын засгийн газарт мэдэгдсэн байв.

Дараа нь холбоотны гэрээ байгуулах асуудлаар явагдсан Зөвлөлт-Хятадын хэлэлцээний үед Бүгд Найрамдах Монгол Ард Улсын бүрэн эрхт байдлын тухай асуудал хэлэлцсэн юм. ЗСБНХУ, Хятадын хооронд найрамдал, холбооны тухай гэрээнд 1945 оны наймдугаар сарын 14-нд гарын үсэг зурах үеэр тус хоёр орны Гадаад явдлын яамны сайд нар БНМАУ-ын төрийн тусгаар тогтнолын асуудлаар нот солилцжээ. Хятадын засгийн газрын нотод: «Гадаад Монголын ард түмэн тусгаар тогтнохыг удаа дараагаар хүсч эрмэлзсэн учир дундад улсын засгийн газраас илэрхийлэх нь Японыг дарсны дараа гадаад Монголын ард түмний нийтийн хүсэл энэ эрмэлзлээ батлах ахул Дундад улсын засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн байгаа хилээр нь зөвшөөрч байна»<sup>13</sup> гэж дурджээ. Үүний хариу ЗСБНХУ-ын засгийн газрын нотод: «Зөвлөлт засгийн газар Дундад Иргэн Улсын засгийн газрын дээр тодорхойлсон нот бичгийг сэтгэл ханамжтай хүлээн авч өөрийн зүгээс илэрхийлэх нь тус Зөвлөлт засгийн газар Бүгд Найрамдах Монгол Ард Улс (Гадаад Монгол)-ын төрийн тусгаар тогтнол ба нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэн үзнэ»<sup>14</sup> гэж мэдэгджээ. 1945 оны наймдугаар сарын 24-нд ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчид, Бүгд Найрамдах Хятад улсын хууль тогтоох зөвлөл найрамдал, холбооны тухай гэрээ, холбогдох хэлэлцээрүүдийг нэгэн зэрэг баталсан байна.

Америкийн монголч эрдэмтэн О. Латтимор БНМАУ-ын тусгаар тогтнолыг Хятад хүлээн зөвшөөрсний ач холбогдлыг тэмдэглэж «Энэ хүлээн зөвшөөрөлтийн үндэс суурь нь Ялтын бага хурлаар бэлтгэгдсэн юм»<sup>15</sup> гэж бичжээ.

Монголын ард түмний төрийн тусгаар тогтнолоо хадгалах эрмэлзлийг дахин нотлохын тулд БНМАУ-ын засгийн газар бүх нийтийн санал хураалт явуулахаар шийдвэрлэж, тийм санал хураалт 1945 оны аравдугаар сарын 20-нд болжээ. Санал хураалтын дүн нь Монголын ард түмний эв нэгдэл, өндөр эх оронч үзэл, улс төрийн ухамсрын тод илэрхийлэл болж, төрийн тусгаар тогтнолынхоо төлөө 100 хувь санал өгсөн байна.<sup>16</sup> Ингээд Монголын ард түмний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлынхаа төлөө хүсэл зориггоо илэрхийлснийг Хятадын засгийн газар арга буюу харгал-

11. Тегеран-Ялта-Потсдам. Сборник док. изд. 2. М. 1970, с. 199

12. Советско-монгольские отношения. Сборник документов, 1921—1966. М. 1966, с. 147

13. Монгол-Зөвлөлтийн харилцаа (1921—1974), боть. 2. УБ. 1981. 141-р тал.

14. Мөн тэнд. 142-р тал

15. O. Lattimore. The Outer Mongolian Horizon. -"Foreign Affairs", vol. 24, 1946, N 4, p. 657.

16. История МНР. М. 1954, с. 338

зан үзэх болсон билээ. Монголын ард түмний улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухааны салбарт олсон ололт амжилт, БНМАУ-ын олон улсын нэр хүнд бэхэжсэн, БНМАУ-ын үндсэн эрх ашгийг олон улсын тавцан дээр ЗХУ тууштай хамгаалж байсан нь Хятадын гоминданы засгийн газар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн юм.

Хятадын засгийн газар 1946 оны нэгдүгээр сарын 5-нд БНМАУ-ын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрчээ. Чунцинд 1946 оны нэгдүгээр сарын 5-нд нийтлэгдсэн албан мэдээнд «..Бүх нийтийн санал хураалт нь Гадаад Монголын ард түмний тусгаар тогтнох хүсэл эрмэлзлийг нотоллоо. Батлан хамгаалах Дээд Зөвлөллийн шийдвэрийн дагуу Үндэсний засгийн газар үүгээр Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч байна»<sup>17</sup> гэж Хятадын засгийн газар мэдэгджээ.

БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхдөө гоминданы Хятадын ноёлогч бүлгийнхэн тусгаар тогтнолыг Монголын ард түмэнд «бэлэглэсэн» мэт ойлголт төрүүлэх оролдлого хийж байв. Удалгүй БНМАУ Чунцинд засгийн газрын төлөөлөгчдөө явуулж гоминданы засгийн газартай хэлэлцээ хийж, 1946 оны хоёрдугаар сард БНМАУ, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосон тухай нот солилцжээ. Ингээд 1946 оны хоёрдугаар сарын 13-нд Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Хятадын Бүгд Найрамдах Улсын хооронд дипломат харилцаа тогтоож, үүгээр БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг Хятадын засгийн газар хүлээн зөвшөөрсөн нь албан ёсоор нотлогдсон байна. Гэвч БНМАУ-ын талаарх гоминданы харгис хүчний дайсагнасан үйл ажиллагаа зогсоогүй байлаа. Тэд 1947 — 1948 онд БНМАУ-ын баруун хилийн орчмын газар нутгийг таслан авах оролдлого хийж байв. БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1946 оны хоёрдугаар сарын 27-нд байгуулсан найрамдал, хамтын ажиллагааны тухай гэрээ нь БНМАУ-ын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гоминданы харгис хүчний түрэмгийлэлийн аюулаас бүрэн хамгаалах баталгаа болох улс төрийн чухал ач холбогдолтой байв.

БНМАУ-ын засгийн газар гоминданы засгийн газартай албан ёсоор харилцаагаа тасалж, ардын хувьсгал ялсан БНХАУ-ыг 1949 оны арав дугаар сарын 6-нд хүлээн зөвшөөрч, мөн сарын 16-нд дипломат харилцаа тогтоосон юм.

ЗСБНХУ, БНХАУ-ын Гадаад явдлын яамны сайд нар хоёр орны хооронд найрамдал, холбоо, харилцан туслалцах тухай гэрээнд 1950 оны хоёрдугаар сарын 14-нд Москвад гарын үсэг зурах үеэр нот солилцжээ. Энэ нотод: «Гадаад Монголд тусгаар тогтнох хүсэл эрмэлзлийг нь нотолсон бүх нийтийн санал хураалт 1945 онд явуулсан хийгээд тус орон той БНХАУ дипломат харилцаа тогтоосоны дүнд БНМАУ-ын тусгаар тогтносон байдал бүрэн хангагдсаныг харилцан тохирогч хоёр тал хүлээн зөвшөөрч байна»<sup>18</sup> гэж дурджээ. Ингэж нот солилцсон нь улс төр, олон улсын чухал ач холбогдолтой болсон юм. Учир нь ингэснээр БНХАУ-ын засгийн газар БНМАУ-ын тусгаар тогтнолыг гоминданы засгийн газар хүлээн зөвшөөрсөн эрх зүйн баримт бичгийн хүчин төгөлдрийг албан ёсоор нотолжээ.

Социализмын орны энх тайванч гадаад бодлогын зарчмуудыг тууштай баримталсан БНМАУ дэлхийн II дайнд фашист Герман, милитарист

17. БНМАУ-ын ГЯЯ-ны архив. П-№ 3

18. Документы внешней политики СССР, Т. VII. М. 1963. с. 710

Японы эсрэг улс түмний аугаа их тулалдаанд ЗХУ, холбоотон гүрнүүдийн талд бат бэх зогсож идэвхтэй оролцсон билээ. БНМАУ өөрийн Зэвсэгт хүчин, 80 мянган хүнтэй армиар 1945 онд Японы милитаризмыг бутцохиход оролцож дэлхийн дайнд фашизм, милитаризмын эсрэг тэмцэлд тодорхой хувь нэмэр оруулсан юм.

ЗХУ болон фашизмын эсрэг холбоотон бусад гүрнүүдийн санаачлан байгуулсан даян дэлхийд энх тайван, улс түмний аюулгүй байдлыг сахин хамгаалах зорилго бүхий олон улсын байгууллага-Нэгдсэн Үндэстний байгууллагын гишүүн байх бүх болзлыг БНМАУ бүрэн хангаж байв.

БНМАУ Нэгдсэн Үндэстний байгууллагад орох хүсэлтээ 1946 оноос эхлэн илэрхийлсэн боловч империалист гүрнүүд НҮБ-д социалист орны тоо нэмэгдэж нөлөө нь ихсэнэ гэж үзэж БНМАУ-ыг аль болохоор элсүүлэхгүй байхын төлөө улайран зүтгэж хиймэл шалтаг, шалтгаан гарган олон жилээр хойшлуулсан билээ. НҮБ дэх Чан Кайшигийн төлөөлөгч БНМАУ-ыг Хятадын хэсэг мэтээр гүтгэн дайрч НҮБ-д элсэхэд саад хийж байв. НҮБ-д БНМАУ-ын орох хүсэлтийг ЗХУ эрс шийдвэртэй дэмжиж, мөн социалист бусад орнууд болон нэлээд тооны хөгжиж байгаа орнууд дэмжиж байв. Хөгжиж байгаа орнуудаас Энэтхэгийн засгийн газар БНМАУ-ыг НҮБ-д оруулахын төлөө тууштай бодлого баримталж байжээ. Тухайлбал Энэтхэгийн ерөнхий сайд Дж.Неру НҮБ ын Ерөнхий Ассамблейн XV чуулган дээр 1960 оны аравдугаар сарын 3-нд үг хэлэхдээ: «... Хэрвээ бид НҮБ-д олон орныг үнэн зөвөөр оруулж байгаа юм бол Монголыг яагаад НҮБ-д элсүүлэхгүй байгаа юм бэ?... Олон улсын хамтын нийгэмлэгийн энэ байгууллагад Монголыг элсүүлж авахыг би эрс шийдвэртэй зөвлөж байна»<sup>19</sup> гэжээ.

БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхийн төлөө ЗХУ-ын гаргасан их хүч чармайлтын үр дүнд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XVI чуулган дээр БНМАУ-ыг элсүүлэхэд АНУ-ын гар хөл бологч Чан Кайшигийн төлөөлөгч саад хийж чадахгүй болсон юм. Ингээд ЗХУ-ын төлөөлөгчдийн тэргүүний БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхийг санал болгож оруулсан тогтоолын төслийг НҮБ-ын гишүүн орнууд санал нэгтэй баталж, 15 жилийн шаргуу тэмцэл, ЗХУ, социалист бусад орнууд, энхийг эрхэмлэгч зарим улсын дэмжлэгтэйгээр БНМАУ НҮБ-д хууль ёсныхоо байрыг 1961 онд эзэлсэн билээ.

БНМАУ НҮБ-д элссэн нь олон улсын амин чухал асуудлуудыг бүх нийтийн энх тайван, улс түмний найрамдлын эрх ашгийн үүднээс үр бүтээлтэй шийдвэрлэхийн төлөө энх тайванч гадаад бодлогынхоо үйл ажиллагааг идэвхжүүлэх өргөн боломжийг тус орны өмнө нээсэн чухал үйл явдал болсон юм. Үүний хамт НҮБ дэх социалист орнууд болон энхийг эрхэмлэгч бусад дэвшилт улс түмний байр суурийг бэхжүүлж, БНМАУ-ын нэр хүндийг өндөрт өргөв. Мөн Монголын тусгаар тогтнолыг «үл зөвшөөрөх» АНУ, түүний холбоотон гүрнүүдийн баримталж байсан бодлого нь балран унаж БНМАУ-ыг олон улс өргөнөөр хүлээн зөвшөөрөх зам нээгдсэн билээ. НҮБ-д манай улс элссэн үеэс эхлэн социалист хамтын нөхөрлөлийн орнуудын нэгэн адил НҮБ-ын дүрмийн үндсэн зарчим, заалтуудыг хэлбэрэлтгүй биелүүлэх, олон улсын харилцаанд дэлхийн хамтын нийгэмлэгийн гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, НҮБ-ыг даян дэлхийд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалж,

19. Правда, 21 октября 1960 г.

хамтын ажиллагаа хөгжүүлэх үр нөлөөтэй хэрэглүүр болгохын төлөө тууштай тэмцэж ирлээ.

БНМАУ зэвсэг хураах болон энх тайвныг сахин хамгаалах асуудлаар санаачилга гарган тодорхой санал дэвшүүлсэн нь дэлхийн олонхи орны дэмжлэгийг хүлээж байв. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулган 1978 онд манай улсын санаачилгын үндсэн дээр зэвсэг хураах зорилгод тус дөхөм үзүүлэх 7 хоногийг зохион явуулах тухай шийдвэр гаргасан бөгөөд уг арга хэмжээг олон улсын хэмжээнд жил бүр хэрэгжүүлж байгаа нь зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, зэвсэг хураахын ач холбогдлыг дэлхийн олон нийтэд өргөн сурталчлахад хувь нэмэр оруулж байна. Мөн 1984 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн ээлжит чуулганд «Улс - түмэн энх тайван орших эрхийн тухай» асуудлыг оруулан хэлэлцүүлж уг асуудлаар тунхаглал батлуулсан нь цөмийн дайны аюул нэн ихэссэн олон улсын өнөөгийн түгшүүртэй нөхцөлд улс түмний энх тунх аж төрөх салшгүй эрхийг нотолсон чухал ач холбогдолтой болсон билээ.

Азийн социалист орны хувьд тус тивийн энх тайван, аюулгүй байдлыг хангахын төлөө БНМАУ НҮБ-ын хүрээнд их хүч чармайлт гаргаж ирэв.

Тус тивийн байдлыг бүхэлд нь сайжруулахад чиглэсэн Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах талаар БНМАУ-ын дэвшүүлсэн санал нь НҮБ-ын дүрмийн зорилго, зарчимд бүрэн нийцэж байгаа юм.

БНМАУ даян дэлхийд бат бэх энх тайван, аюулгүй байдал, үндэсний тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө социалист орнууд, энхийг эрхэмлэгч бүх хүчний тэмцэлд хувь нэмэр оруулж байна.

МАХН-ын XIX их хурал БНМАУ-ын гадаад харилцаа үлэмж өргөжиж, түүний олон улсын харилцааны үйл ажиллагаа мэдэгдэхүйц идэвхжин, социалист Монголын нэр хүнд өссөнийг тэмдэглэсэн билээ.

НҮБ болон олон улсын бусад байгууллагуудад манай улсын үйл ажиллагаа идэвхиж БНМАУ одоо 101 оронтой дипломат, 40 гаруй оронтой худалдаа эдийн засаг, соёлын харилцаатай, олон улсын 60 байгууллагын гишүүн бөгөөд олон талын өдий төдий гэрээ хэлэлцээр, конвентузд оролцож байна

Энэ бүхэн нь БНМАУ-ын тусгаар тогтнол, олон улсын байр суурийг бэхжүүлэх талаар ЗХУ-аас гаргасан хүчин чармайлттай салшгүй холбоотой бөгөөд БНМАУ-ын олон улсын байр суурийг хэлбэрэлтгүй бэхжүүлж байна.